

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХУНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2024 оны 05 дугаар сарын 14-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 4-17

1. Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 17 гишүүн 2024.04.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ 5-12

2. Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ 12-17

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
05 дугаар сарын 14-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Ж.Батжаргал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 36 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Анандбазар, Т.Аубакир, Ц.Идэрбат, Г.Мөнхцэцэг, Ц.Цэрэнпунцаг;
Чөлөөтэй: Г.Ганболд, Д.Өнөрболор, Ц.Туваан, Т.Энхтүвшин.

Байнгын хорооны дарга Ж.Батжаргал Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хог хаягдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүнсний тухай хуульд нэмэлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хойшлуулах горимын санал гаргав.

Ж.Батжаргал: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Нэг.Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд
/Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 17 гишүүн 2024.04.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, мөн яамны Мал эмнэлгийн бодлогын асуудал эрхэлсэн ахлах шинжээч Х.Алтангэрэл, Бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн Ц.Мөнхнасан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Мажигсүрэн, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн танилцуулав.

Төслийн үзэл баримтлалын талаар Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен, Х.Болорчулуун нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен, Ж.Батжаргал нар үг хэлэв.

Ж.Батжаргал: Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, мөн яамны Мал эмнэлгийн бодлогын асуудал эрхэлсэн ахлах шинжээч Х.Алтангэрэл, Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Статистик, дүн шинжилгээ хариуцсан ахлах мэргэжилтэн С.Батхуяг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун танилцуулав.

Төслийн үзэл баримтлалын талаар Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар, Г.Тэмүүлэн нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал эмнэлгийн бодлогын асуудал эрхэлсэн ахлах шинжээч Х.Алтангэрэл нар хариулж, тайлбар хийв.

Ж.Батжаргал: Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4

Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 52 минут үргэлжилж, ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр 11 цаг 28 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТЖАРГАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 05 дугаар сарын 14-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
10 цаг 36 минут.

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Батжаргал: Байнгын хорооны гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2024 оны 5 дугаар сарын 14-ний хуралдаанд Байнгын хорооны 10 гишүүн хүрэлцэн ирж, 52,6 хувийн ирцтэй байгаа тул хуралдаан эхлэх бололцоотой ирц бүрдсэн байна. Өнөөдрийн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал, Жадамбын Бат-Эрдэнэ, Батсүхийн Саранчимэг, Буланы Бейсен, Хаянгаагийн Болорчулуун, Наянтайн Ганибал, Гонгорын Дамдинням, Нанзадын Наранбаатар, Ганзоригийн Тэмүүлэн, Одонгийн Цогтгэрэл нар хүрэлцэн ирж ирц бүрдсэн тул хуралдааныг эхлүүлж байна.

Өнөөдрийн хуралдаанаар дараах 5 асуудал хэлэлцэгдэхээр төлөвлөгөөнд туссан байна. Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 17 гишүүн 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх. Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд, Монгол Улсын ЗГ 2024 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх. 3.Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төсөл, Улсын Их Хурлын гишүүн Батжаргал нарын 38 гишүүн 2024 оны 3 дугаар сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг.

4.Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төсөл, ЗГ 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг. 5.Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хог хаягдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүнсний тухай хуульд нэмэлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүд, ЗГ 2024 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хамт өргөн мэдүүлсэн хуулиуд, анхны хэлэлцүүлэг, санал дүгнэлтээ ТББХ-нд хүргүүлэх. Ийм 5 асуудал хэлэлцэгдэхээр орж ирж байгаа юм.

Сүүлийн 3 асуудал хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсгүүд нь хуралдаагүй байгаа тул энэ удаагийн хуралдаанаас хойшлуулах нь зүйтэй гэсэн ийм зарчмын зөрүүтэй горимын санал гаргаж байна. Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулиуд, Саяын тэр Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагуулж өргөн мэдүүлсэн манай Байнгын хороотой хамаарах 6 хууль байгаа тийм ээ, 6 хуулийг ажлын хэсгүүд яагаагүй хуралдаагүй байгаа тул хойшлуулах, энэ удаагийн хуралдаанаас хойшлуулах санал гаргаж байна. Өөр саналтай гишүүд бий юу, хэлэлцэх асуудалтай холбогдуулж?

Тэгвэл саяын горимын саналаар санал хураачихъя тэгэх үү. 3 асуудлаа хойшлуулчихъя гээд. Дэмжиж байгаа гишүүд саналаа өгье. Санал хураалт.

Хуралдаанд оролцсон гишүүдийн 60 хувь нь дэмжиж, горимын санал дэмжигдлээ. Малчны тухай хууль, түүнийг дагуулж хамт өргөн мэдүүлсэн хуулиуд, Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл хамт өргөн мэдүүлсэн хуулиудыг хэлэлцэхээр өнөөдрийн хуралдаанаар тогтлоо. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг. Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 17 гишүүн 2024.04.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн танилцуулгыг хуулийн төсөл өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн танилцуулна. Тэмүүлэн гишүүнийг микрофоныг өгье.

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны дарга, гишүүддээ энэ өглөөний мэндийг хүргэе. Та бүхэнд Малчны тухай хуулийн төслийн талаарх хуулийн төслийн үзэл баримтлал болоод хуулийн төслийн талаарх танилцуулгыг бас танилцуулгыг хийе. Өнөөдөр үндсэндээ Монгол Улсад болбол 300 мянга гаруй малчид маань бас мал аж ахуйн салбарт ажиллаж, энэ салбарын хөдөлмөр энэ салбарт хөдөлмөр эрхэлж, энэ салбарын талаар одоо бас үйл ажиллагаагаа бол явуулж байна. Үүнтэй холбоотойгоор бид нарын хувьд энэ нийт Монгол Улсад байгаа 298 мянган малчдын эрх ашгийг хамгаалах, малчдын маань ажиллах, амьдрах, тогтвортой үйл ажиллагаагаа эрхлэх, мөн цаашилаад мэдлэг боловсролоо дээшлүүлэх, үйлдвэр эрхлэх таатай нөхцөлийг болбол бүрдүүлэх зайлиггүй шаардлагатай байгаа. Энэ үндсэн дээр бид бүхний хувьд энэ хуулийн төслийг болбол бас боловсруулсан.

Манай мал аж ахуйн салбар болбол үндсэндээ улс орны үндэсний энэ тулгуур одоо бас эдийн засгийн салбар байгаад байгаа. Тэгэхээр бид нар энэ мал

аж ахуйн салбарыг хэрхэн цаашид эдийн засагжуулах вэ, байгальд ээлтэй болоод бүтээмжтэй, эрсдэлгүй мал аж ахуйг хөгжүүлэх вэ гэдэг болбол энэ гол үндсэн хуулийн маань болбол бас үзэл санаа байгаа. Тэгээд хуулийн хамрах хүрээ маань болбол нэг талдаа бид нар бас нэг талдаа төрөөс мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих бодлогыг болбол бас төрөөс тодорхой болгоё гэдэг зохицуулалтыг бол оруулж ирсэн. Магадгүй сүүлийн 20, 30 жилийн хугацаанд малчин хүнтэй холбоотой газрын дээрх хамгийн үнэ цэнтэй баялаг болсон малчныг талаар төрөөс хамгаалах, дэмжих бодлого болбол үгүйлэгдэж байна. Монголын төрөөс энэ талаар тодорхой бодлого чиглэл, бодлогоо тодорхой болгох зайлиггүй шаардлагатай байна гэж бол гарч ирсэн.

Тэгэхээр болбол төрийн хүлээх эрх, үүргүүдийг болбол тодорхойлж, энэ хуулийн хүрээнд цаашид төрийн байгууллагууд болоод бусад хууль хоорондын нийцлүүдийг хангах, мөн бид бүхний бас өмнөх жилүүдэд баталж байсан Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Малын генетик нөөцийн тухай хууль, Хориооны тухай хууль болон бусад хоорондын энэ хууль хоорондын уялдаа холбоог хангах дээр болбол бас онцгойрч болбол ажилласан байгаад байгаа.

Энэ хууль дээр бас нэг анхаарах ёстой зүйл маань болбол бид нар энэ малчин хүнээ хөгжүүлэх бодлого маань болбол бас их малчныхаа хөгжлийг дэмжих энэ бодлогыг болбол төрөөс тодорхойлох нь зүйтэй байна. Үүнтэйгээ холбогдуулж бид бүхэн цаашидаа ер нь 21 дүгээр зуунд мэдлэг боловсролтой, ухаалаг малчныг хэрхэн бий болгох вэ, илүү амьжиргаа, орлого сайтай, илүү энэ салбарыг хэрхэн эдийн засагжуулах вэ ч гэдэг юм уу энэ асуудлуудыг болбол тусгаж өгсөн байгаад байгаа. Тэгэхээр малчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, мэргэшүүлэх үндсэн дээр болбол үндэсний хэмжээнд бас сургалтын нэгдсэн стандарт хөтөлбөртэй болбол

болох нь зүйтэй байна. Аймгийн мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдээр дамжуулж малчдыгаа 3-аас 5 жилийн хугацаанд давтан сургах, мэргэшүүлэх сургалтуудыг хийж, малчдыг үнэмлэхжүүлэх энэ ажлуудыг болбол хийх нь зүйтэй байна гэж болбол бас үзсэн.

Мөн орон нутгийн түвшинд авч үзэх юм болбол малчны хөгжлийг дэмжих үүднээс малчны хөгжлийн төвүүдийг сум болон аймгийн төвүүд дээр байгуулж хөгжүүлэх, үүгээрээ дамжуулж тухайн тэр малчныг мэдлэг чадвар, боловсролыг нь дээшлүүлэх, чадавхжуулах сургалтуудыг хийдэг байх. Сум орон нутаг, аймгаас болбол тодорхой хэмжээний санхүүжилтүүдийг зохицуулалт гаргаж, үүгээрээ дамжуулж малчныхаа хөгжүүлэх үйл ажиллагааг явуулдаг байх энэ зохицуулалтуудыг болбол бас оруулж өгсөн байгаад байгаа.

Мөн дээрээс нь бид нар Монголын төрөөс сум, аймаг, үндэсний түвшинд ч тэр, ер нь малчдынхаа идэвх оролцоог дэмжих үүднээс малчны идэвх оролцоог дэмжих саналыг авах, малчныг сонсох өдөртэй байцгаая, 365 өдрөөс болбол нэг өдрийг нь болбол малчныг сонсох өдрийг болбол зохицуулалт оруулж өгч, үүн дотроо бас ахлах, ахмад малчид маань залуу малчдадаа зааж сургаж, сум орон нутгийн удирдлагууд маань болбол тухайн тэр намар болоод өвөлжилт, хаваржилтынхаа бэлтгэлийг хамтын зохион байгуулалтын хүчээр бас шийдвэрлэдэг, гарц шийдлээ хамтдаа ярьдаг, Төрийнхөө ордондоо улсын аварга малчид болоод тэргүүний, аварга, одоо аварга малчдаа бас цуглуулж, тухайн мал аж ахуйнхаа хөгжлийн талаар бас бодлого шийдвэр ярилцдаг байх ийм өдөртэй байхаар болбол бас зохицуулж өгсөн байгаад байгаа. Энэ болбол цаашидаа Монгол Улсын мал аж ахуйн салбарын тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх гарц шийдлийг тодорхой болгох бас тодорхой зохицуулалт болно гэж болбол бас үзсэн.

Нөгөө талдаа бид нар төрөөс малчин хүнээ дэмжих, мал аж ахуйн салбараа дэмжихээс гадна болбол малчин хүнд хүлээлгэх үүрэг хариуцлагуудыг тодорхой болгох шаардлагатай байна. Хариуцлагатай малчны хэрэгжүүлэх, хэрэгжүүлдэг гэдэг юм уу зохистой дадлуудыг болбол энэ хуульчилж оруулж өгсөн. Хуучин ахмадууд маань болбол хаврын 13, намрын 8 гэдэг технологийн ажлуудыг, малын малын эрүүл мэнд болон үржил технологийн ажлуудыг цаг график хугацаанд нь хийдэг байсныг энэ хуулийн хүрээнд хариуцлагатай малчинд тавигдах тодорхой шаардлага, шалгуур бий болгож, цаашидаа улс, аймаг, сумын аварга малчдыг шалгаруулахад эдгээр зохистой дадлуудыг үнэлж үнэлгээжүүлдэг байх, мөн төр засгаас эдгээр үнэлгээжүүлэх энэ аргачлалыг боловсруулж, үндэсний хэмжээнд нэвтрүүлэх зохицуулалтыг бас бий болгож өгсөн байгаа.

Саяын тэр бэлчээр, тэжээл болоод усан хангамж, ашиглалттай холбоотой, арчилгаа маллагааны арга барилтай холбоотой, малын үржүүлэг, технологийн ажилтай холбоотой, малын эрүүл мэнд болоод түүхий эд, бүтээгдэхүүний чанар, бэлтгэн нийлүүлэлттэй холбоотой 28 зохистой дадлыг болбол энэ хуулийн хүрээнд хуульчилж, эдгээр 4 малчинд тавигдах үүргийн хүрээнд цаашидаа нэвтрүүлбэл магадгүй мал аж ахуйд тавигдах энэ хөдөлмөрийн бүтээмж, үр ашиг нэмэгдэх, энэ салбарын үр өгөөж илүү өндөр түвшинд гарч ирэх боломж бололцоо болбол бүрдэнэ гэж болбол харж байгаа.

Бид нарын хувьд одоо бас энэ мал аж ахуйн салбарын маань үйлдвэрлэлийг дэмжих үүднээс малчин хүний бүтээмж, үр ашгийг тооцдог байх. Үүн талаарх аргачлалыг болбол үндэсний хэмжээнд болбол бий болгож, үндэсний хэмжээнд нэвтрүүлэх зайлиггүй шаардлагатай байна гэж үзэж байгаа. Тэгэхээр

үндсэндээ малчин хүний нэгж малаас авах бүтээмжийг дээшлүүлэх, үр өгөөжийг нэмэгдүүлэх хүрээнд болбол бүтээмжит мал аж ахуйн салбарын бүтээмж болон малчны бүтээмж гэдэг тодорхойлолтыг болбол хуулийн хүрээнд гаргаж ирж, үүн дотор голлох хүчин зүйлс болох малчны боловсрол, малын эрүүл мэнд болон үржил селекц технологийн ажил, түүнтэй холбоотой, мал маллагаатай холбоотой асуудлууд, тэжээл хангамж, хашаа хороо болон мал аж ахуйн үйл ажиллагааг хөнгөвчлөх шинэ арга техник, технологи зэрэг энэ асуудлууд дээр болбол төрөөс тодорхой дэмжлэг тусалцаа үзүүлж, малчны бүтээмжийг нэмэгдүүлэх, малчин хүний хөдөлмөрийн үр ашгийг нэмэгдүүлэхэд болбол төрөөс анхаарах зохицуулалт, тогтолцоо зохицуулалтуудыг болбол хийж өгье гэсэн байгаа.

Үүн дээрээсээ хамаараад мөн түрүүний хэлсэнчлэн малчин хүн хариуцлагатай малчин хүний нэвтрүүлэг зохистой дадал дээр нэмэх нь эдгээр мал аж ахуйн бүтээмжүүдээс хамаарсан түүхий эдийн нэр төрөл болоод чанарын үнэлэмжээс хамаарсан урамшуулал, үнэлгээний тогтолцоог болбол бас үндэсний хэмжээнд нэвтрүүлцгээе. Ингэж байж цаашидаа болбол магадгүй тухайн хүний хариуцлагатай байдлаас нь хамаарч тухайн хүний одоо юу гэдэг юм хөдөлмөрийнх нь бүтээмж, үр ашгаас нь хамаарч тухайн үнэлгээжүүлдэг, урамшуулдаг, шагнадаг энэ тогтолцоо болбол үндэсний хэмжээнд нэвтрүүлэх нь энэ мал аж ахуйн үйлдвэрлэлд цаашидаа томоохон бодлогын өөрчлөлт болох болов уу гэсэн үндсэн дээр болбол бас оруулж өгсөн байгаа.

Эргээгээд малчин хүнд бас хамгийн хүндрэлтэй нэг зүйл нь болбол банк санхүүгийн үйлчилгээ байдаг. Төрөөс үзүүлэх энэ санхүүгийн үйлчилгээн дээр арилжааны банкнуудаас үзүүлж байгаа санхүүгийн үйлчилгээн дээр болбол тодорхой хөнгөлөлттэй болон нэн хөнгөлөлттэй зээлийн зохицуулалтуудыг бас оруулж өгөх нь

зүйтэй байна гэж болбол оруулж өгсөн байгаад байгаа. Энэ салбарт бас нэг дутагдаад байгаа зүйл маань болбол өөрөө юу юм бэ гэхээр энэ түүхий эд бүтээгдэхүүнд, мөн мал, мал болоод малын гаралтай энэ өмч хөрөнгө дээр болбол биет үнэлгээ хийх, хөдлөх хөрөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулахад чиглэсэн зөвлөх үйлчилгээг төрөөс дэмжих зайлиггүй шаардлагатай байна. Тэгэхээр үндсэндээ мал аж ахуйн салбарт дутагдаж байгаа зүйл маань болбол энэ үнэлгээжүүлэлтийн асуудал, хөрөнгийн үнэлгээний асуудлууд байна. Мөн энэ санхүүгийн үйлчилгээтэй холбоотой зөвлөх үйлчилгээнүүдийг нэвтрүүлэх байгаад байдаг.

Бусад салбаруудад байдаг мөртөө өнөөдөр мал аж ахуйн салбарын хөгжил бас өөрөө гацанг байдалд орж байгаа суурь шалтгаан болбол энэ. Тухайн энэ хөрөнгийн үнэлгээ, санхүүгийн зөвлөх үйлчилгээтэй холбоотой асуудлуудыг төрөөс дэмжих зохицуулалтыг хийх, малчин хүн бас энэ чиглэлээр өөрийнхөө эрх ашгийг хамгаалуулах боломж бололцоог бүрдүүлнэ гэж болбол харж байгаа.

Ингээд энэ хууль цаашид батлагдсанаараа бид бүхэн бас энэ мал аж ахуйн салбарын бүтээмж, үр өгөөжийг дээшлүүлэх, чанартай түүхий эд бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо бүрдэх, малчин хүн мал аж ахуйн үйлдвэрлэлээ цаашид нутаг орондоо тогтвортой эрхлэх боломж бололцоо бүрдэх байх. Том зургаараа болбол Монгол Улсад энэ нэг талдаа бас үр ашиг өндөр бүхий ухаалаг мал аж ахуй бий болох боломж бүрдэж, мэдлэг боловсролтой малчдыг төрөөс дэмждэг, мал аж ахуйн чадалтай боловсон хүчнийг дэмжих боломж бололцоо болбол бүрдэнэ гэж болбол үзсэн байгаад байгаа.

Тэгээд энэ хуулийн төслийг Байнгын хорооны гишүүд маань одоо дэмжиж, хэлэлцэхийг нь дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа та бүхэнд.

Ж.Батжаргал: Тэмүүлэн гишүүнд баярлалаа. Хэлэлцээж буй асуудалтай холбогдуулж хүрэлцэн ирсэн ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Э.Цолмонжаргал ХХААХҮЯ-ны Хуулийн хэлтсийн дарга, Х.Алтангэрэл ХХААХҮЯ-ны Мал эмнэлгийн бодлогын асуудал эрхэлсэн ахлах шинжээч, Ц.Мөнхнасан, ХХААХҮЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын мэргэжилтэн. Хуулийн төслийн танилцуулгаас асуух асуулттай гишүүд байна уу? Нэрсээ өгье. Болорчулуун гишүүнээр тасаллаа. Бейсен гишүүн асуултаа асууя.

Б.Бейсен: Хуулийн төслийг дэмжиж байгаа. Малчдын тэтгэвэр тэтгэмжийг нөхөн төлүүлэх асуудал дээр нэлээн анхаарахгүй бол одоо малчдыг 55 насанд тэтгэвэрт гарна гээд яриад байгаа бид нар. Гэтэл одоогийн байдлаар ер нь 55 насанд тэтгэвэрт гарах нөхцөлийг хангах хүн байхгүй энэ ерөөсөө. Настай малчид маань амьдрал юмаа гүйцэт үүссэн, залуу малчид нь нийгмийн даатгалын шимтгэлээ төлж чадаагүй. Сая хөдөө явж байхад нөхөн төлүүлж өгөөч гээд урьд нь нэг эртний үед нэг төлүүлсэн, 2 жилийн өмнө бас төлүүлсэн шүү дээ. Одоо нэг анхаарахгүй бол малчдын тэтгэвэр тогтоолгох асуудал нэлээн хүнд байгаа юм байна ерөөсөө. Нөхөн төлүүлж байж тэтгэвэр тогтоолгох боломжтой олон хүн байна. Энэ дээр энэ хуулийн төсөлд сайн тусгаж өгвөл.

2 дугаарт энэ малчдын эрүүл мэндийн асуудал дээр. Бусад малын эрүүл мэндийн асуудлыг Хөдөө аж ахуйн яамныхан сайн оруулсан байна. Малчдын эрүүл мэнд. Малчид эрүүл байж байж малаа маллана шүү дээ. Гэтэл хөдөөгийн малчид маань хөнгөлөлттэй эмээ авч чадахгүй байна. Зарим нь одоо 50-аас 200км-ээс эм хайж явж байна. Сумын түвшинд эмийн сангийн асуудал эмч нь байхгүй, зарим газар зүгээр бага эмч биш бол сувиллагч ажиллаж байна. Тийм учраас энэ дээр анхаараад эмийн сан, эмчтэй нь хамт шийдэхийг нь хуулийн

төсөлд шийдээж тусгаж өгөхгүй бол одоо сумын төв, аймгийн төвийнхөн 500-аас 800 метрийн дотор яваад эм авч байхад тэд нар чинь 200 метрт, одоо 200км дотор яваад тэгээд эм хайгаад явж байна шүү дээ. Энэ дээр анхаараад багийн түвшинд чинь эмийн сангийн асуудал, түрүүн ЭМЯ-ныхан бас ярьсан. Энэ нэлээн орхигдоод байгаа. Энэ дээр анхаарах, анхаараад хуулийн төсөлд тусгаж өгвөл сайн байна.

Ж.Батжаргал: Хариулъя. Тэмүүлэн гишүүн.

Г.Тэмүүлэн: Бейсен гишүүнийхээ асуултад хариулъя. Тэгэхээр өнөөдөр үндсэндээ энэ Монгол Улсын мал аж ахуйн салбарыг авч явж байгаа, тэр дундаа Монгол Улсын өнцөг булан бүрийг, баг, сум бүрийг эзэнтэй байлгаж байгаа, тусгаар тогтнолын баталгаа болсон энэ малчин хүнийг болбол төрөөс бас нийгмийн баталгааг нь хангах, эрүүл мэндийнх нь баталгааг нь хангах болбол зайлшгүй шаардлага байна. Зайлшгүй шаардлагатай байна. Энэ болбол нэг талдаа Монгол төрийн бас хар хайрцгийн би бодлого байх ёстой гэж болбол үзэж байгаа.

Газрын дээрх хамгийн үнэ цэнтэй баялаг болсон бид нар хүнээ хамгаалах дээр болбол Монголын төрөөс бодлого гаргах ёстой гэж болбол харж байгаа. Тэр дундаа нийгмийн баталгаатай холбоотой асуудал болбол хамгийн их орхигдсон байдаг. Өнөөдөр нийт Монгол Улсын 298 мянган малчдын 80 хувь нь нийгмийн баталгааны гадна буюу нийгмийн даатгалын шимтгэл төлдөггүй, ирээдүйд ямар нэг байдлаар төрийн ийм дэмжлэг тусалцаанд орох боломж бололцоо байхгүй, тэтгэвэрт гарах боломж бололцоогүй байна. 2020, 2021 онд бид нар малчдын НДШ нөхөн төлүүлэх тухай хуулийн төслийг өргөн бариад батлуулаад хэрэгжүүлсэн боловч 21 он маань өөрөө эдийн засгийн хүнд нөхцөлтэй, цар тахалтай, хатуу хөл хориотой 5, 6 сар нь одоо юу гэдэг юм малчид амьжиргаа, орлогоо бүрдүүлэх

боломж бололцоо байхгүй хатуу хөл хорионд гацсан ийм жил байсан. Тэгэхээр болбол хууль хэрэгжиж чадаагүй хорьхон мянган малчид нэмэгдэж шинээр орсон. Хувиараа бизнес эрхлэгчдээс 15 мянган хүмүүс хамрагдаж орсон.

Тэгээд өнөөдөр үндсэндээ энэ хуулийн төслийг өргөн мэдүүлэх гээд ингээд боловсруулаад явж байхад болбол гол хүсэж байгаа зүйл нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх заалтыг оруулж өгөөч. Монголын төр энэ зах зээлийн ороо бусгаа цагийн 30 жилийн гол хохирогч болсон малчдад анхаарч нэг удаа ингээд тусалж үзээч. Ажилласан он жил нь дутуу тооцогдсон, архив материал нь байхгүй болчихсон, ажилласан жил нь хүрдэггүй, эргээд бид нар ямар нэг одоо юу гэдэг юм нийгмийн баталгааны гадна орхигдож байгаа бид бүхнийг Монголын төрөөс дэмжиж өгөөч л гэдэг зүйлийг хүсэж байгаа. Тэгээд энэ хуулийн төсөл дээр болбол малчдын энэ нийгмийн баталгааг хангах үүднээс 5 дугаар зүйл дээр нь 26 оны 1 сарын 1 хүртэл малчид НДШ-ээ нөхөн төлүүлэх боломжтой байна гэдэг заалтыг болбол бас оруулж өгсөн. Эргээд ЗГ холбогдох журмыг нь болбол гаргахаар болбол зохицуулалтыг болбол хуулийн төсөл дээр хийсэн байгаа.

Эрүүл мэндтэй холбоотойгоор мөн бас бид нар энэ малчдынхаа эрүүл мэндийн талаар анхаарахгүй болбол цаашид болохгүй байна. Жилийн 4 улирал, тэр дундаа хаврын тарчиг хүнд цагаар бүтэн нойртой хонодог малчин гэж байхгүй. Өөрийгөө гаргуунд нь хаяад, өөрийнхөө эрүүл мэндийг бас нэг талдаа гаргуунд хаяад зүтгэдэг хүмүүс бол малчин байгаад байгаа. Бусад төрийн албан хаагч нар болоод бусад одоо салбарын хүмүүсээс ялгагдах нь. Жилийн 365 өдөр ямар нэг амралт, нойр хоолгүй явдаг хүмүүс. Тэгэхээр энэ үндсэн дээр болбол малчдыг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд Монголын төрөөс үнэ төлбөргүй жил бүр хамруулах зохицуулалтыг бас хуулийн төсөл дээр тусгасан байгаад байгаа. Тэгээд цааш

цаашидаа бид нар малчдаа энэ урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, эрүүл мэндийг нь ямар нэг өвчинд нэрвэгдэхээс нь өмнө болбол хамгаалдаг тогтолцоо болбол зайлигүй шаардлагатай л гэж болбол үзсэн.

Ж.Батжаргал: Бейсен гишүүн тодруулъя.

Б.Бейсен: Энэ малчдын эрүүл мэндийн асуудлаар бас нэг хэлэх асуудал байна. Энэ алсын түргэн тусламж хөдөөд явдаг. Энэ алсын түргэн тусламж бол зөвхөн малчид л зөөгдөнө шүү дээ. Гэтэл машин маань фургон машин харвалт өгсөн, жирэмсэн эх, тэгээд гэмтэл хугаралтай улсуудыг тээвэрлэх боломжгүй, тэгээд наадах чинь ЭМЯ-ныхан бас анхаарч байгаа, сайд бас тэгж байгаа. Одоо ингээд туулах чадвар сайтай жийп машин, зориулалтын машин гээд энийг бас тусгахгүй бол зөвхөн хот дотор л тийм машин яваад байдаг. Хөдөө сумын багийн түвшинд бараг фургон машин явж байгаа шүү дээ.

2 дугаарт энэ өвөлжилтийн бэлтгэл ажлыг, малчдын нийгмийн баталгааг хангаагүй аймаг, сумын удирдлагууд дээр хариуцлага тооцох асуудал дээр нэлээн анхаарахгүй бол болохгүй нь. Жишээлбэл, Баян-Өлгий аймаг дээр одоо өвөлжилтийн бэлтгэл ажлыг 11 сарын 15-нд хангах ёстой байтал тендерийг зарлахгүй байсаар байгаад сая 2 сарын хэдэнд нэг.../минут дуусав/

Ж.Батжаргал: Санал байлаа. Болорчулуун гишүүн асуултаа асууя.

Х.Болорчулуун: Мэдээж салбарын сайдын хувьд Малчны тухай хуулийг бол дэмжинэ. Энэ хамгийн гол нь манай малчид бол, малчид одоо нүүдэллэж, нүүдэллэж бэлчээр сонгож амьдардаг, ажилладаг. Дуртайдаа нүүдэллэдэггүй. Нэг дор удаад ирэхээр удаан мал сүргээ хариулаад ирэхээр маллаад ирэхээр хөрс ургамлын

доройтол болдог. Тийм учраас өөрийн эрхгүй нүүдэг. Мөн цаг агаарын байдлаас болж нүүдэллэдэг. Ийм учраас уламжлалтаараа болбол дасан зохицох байдал дээр одоо хоорондоо уламжлалт байдал дээр одоо зохицож нүүдэллэж амьдардаг малчид маань болбол иргэд маань. Тэгэхээр энэ дээр болбол бэлчээрийг эдэлбэр газрыг малчдад баталгаажуулна гэж эрхийг баталгаажуулна гээд. Тэгэхээр энэ чинь нэг ёсны тухайн газрыг хуваарилж өгнө гэсэн үг байна шүү дээ. Энэ хил хязгаар тогтоох юм уу, энэ дээр нь хариулаач. Ер нь айхтар их хил газраар тогтоогоод ирвэл энэ уламжлалт бэлчээрийн мал аж ахуйн энэ чанар бол алдагдана шүү. Нөгөө маргаан үүсэх эх үүсвэр болно. Бид нар хоорондоо дасан зохицоод уламжлалаар явж ирсэн олон мянган жилийн түүхтэй гэдгийг хэлье.

Ер нь одоо хөдөө орон нутаг, тал хээрт ялангуяа бүүр хамгийн гол нь нэг л зүйлийг энэ Малчны хууль ч бай, Газрын хуульд ч бай оруулмаар байгаа юм. Юу гэвэл худаг хоорондын зай хэмжээг. Энэ чинь л одоо хамгийн гол нэг нэгийгээ хүндэлж, нэг нэгийнхээ бэлчээрийг харилцан шахаж буугаад бэлчээрийг байхгүй болгохгүй, ургамлын доройтолд оруулахгүй гол үндэс гэж үзэх болно. Ер нь нэг тал хээрт болбол 5км-ээс дотогшоо худаг гаргахгүй энэ тэр байхыг бол хуульчилж оруулмаар байгаа юм. Энүүгээр л зохицуулна. Тэрнээс газрыг хил заагаар хуваарилах энэ тэр бол яавч байж болохгүй асуудал гэж хэлэх байна.

2 дугаарт энэ тал дээр хариулж, энэ яг хөдөө орон нутагт тулгамдаж байгаа асуудал бол малчдын нийгмийн байдал. Одоо өрхийн тэргүүн нь малаа маллаад хөдөө байдаг, хүүхэд нь сургуульд оронгуут 6 настай сургуульд оронгуут эхнэр нь сумын төвд байдаг. Ингээд 2 талд амьдардаг ийм байдал үнэхээр бий болчихоод байна. Энэ тал дээр ч бас хөдөө орон нутгаар явж байхад санал гомдлоо иргэд залуучууд бас хэлж байна. Ер нь тэгээд энэ малчны

хүүхэд бол 6 настай энэ тэр сургуульд орох болбол энэ өөрөө сонголтоор гэж байгаа юм. Тэгээд бараг энэ хуульчлаад тэдэн настай орно гэж яахгүй сонголтоор гэхээр зарим нь орно, зарим нь орохгүй байгаад л ингээд явчхаж байгаа юм. Энэ тал дээр бас нэг энэ нийгмийн асуудал гол болохоор хөндөж хуульд тусгасан зүйл юу байна вэ гэдгийг бас асууя.

Тэгээд сумын төв дээр бас малчдад зориулсан төв энэ тэр байгуулна гэж тэр энэ тэр болбол одоо хэрэг байгаа юм уу? Ер нь нэг одоо яг амьдрал дээр, бодит байдал дээр болбол ашиглагдах нь юу л бол доо гэдгийг бас хэлье.

Ж.Батжаргал: Хариулъя. Тэмүүлэн гишүүний микрофоныг өгье.

Г.Тэмүүлэн: Тэгэхээр энэ малчин өрхтэй холбоотой газрын харилцаатай асуудал болбол бас нэлээн чухал асуудлууд байгаа. Өнөөдөр бид нар энэ Монгол Улсын бэлчээрийн мал аж ахуйн гол амин сүнс нь болбол өөрөө бэлчээр байгаад байгаа. Тэгээд өнөөдрийн яг өнөөгийн тогтолцоогоор, яг өнөөгийн явж байгаа энэ байдлаараа бид нар тодорхой хэмжээнд энэ мал аж ахуйн үйлдвэрлэл өөрөө үр өгөөжөө нэмэгдүүлэх, дээшлүүлэх боломж бололцоо болбол байхгүй байна гэж болбол харж байгаа. Тэгэхээр энэ ч үндсэн дээр Тогтохсүрэн гишүүн болоод хөдөө орон нутгаас сонгогдсон гишүүд бид бүхний хувьд Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн барьсан. Улсын Их Хурал хэлэлцэх эсэхийг нь шийдсэн, анхны хэлэлцүүлэг бас тун удахгүй хийгдэх болов уу, энэ жилдээ багтаж батлагдах болов уу гэсэн таамаглалтай байна.

Энэ тэгэхээр Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар Тогтохсүрэн гишүүн бид нарын хувьд өргөн барьсан хуулийн суурь үзэл санааг нь, суурь үзэл баримтлалыг нь энэ Малчны тухай хууль дээр хийж өгсөн.

Энэ маань өөрөө юу юм бэ гэхээр цаашид бид нар өвөлжөө, хаваржааныхаа газар нутгийг хамтын оролцоонд шийдвэрлэсэн, Багийн хурлаас шийдвэрлэсний дагуу ядаж өвөлжөө, хаваржааныхаа газар нутгийг өнжөөдөг, чөлөөлдөг, амраадаг энэ бодлогын зохицуулалт руу оруулдаг байя. Орон нутагт эрх мэдлийг нь өгье. Багийн хурал хуралдаад тухайн одоо юу гэдэг юм хуучин сум, сангийн аж ахуйн нэгдэл байх үед эргээгээд магадгүй тодорхой улирлын шинж чанартайгаар, цаг хугацааны графиктайгаар тухайн өвөлжөө, хаваржааныхаа газар нутгийг Багийнхаа түвшиндээ хамтаараа шийдүүлж, хамтаараа ашигладаг, хамтаараа хамгаалдаг тогтолцоо руу оруулья л гэсэн ийм зүйл болбол зохицуулалтыг хийж өгсөн. Дээр үед болбол бог, бод нь болбол тусдаа бэлчээрлэдэг байсан. Отрынхоо нөөц газар нутгууд дээр бид нар тодорхой хамгаалалтын зохицуулалтуудыг хийж, Багийнхаа хурлаар одоо юу гэдэг юм чөлөөлдөг, өнжөөдөг, амраадаг ийм зохицуулалтууд байсан. Суурь санаа нь бол энд байгаад байгаа.

Нөгөө талдаа бид нар одоо ер нь болбол тодорхой энэ өвөлжөө, хаваржааны газрыг ямар нэгэн өөр чиглэлээр давхиулж газар ашиглах, эзэмшүүлэх, өөр үйл ажиллагаа явуулах зөвшөөрлүүдийг болбол төрийн байгууллагууд бас олгоод байна. Орон нутгаас олгоод байна. Энийг болбол хууль дээр хориглож өгсөн. Малчин хүний амьжиргаа орлого болсон энэ мал аж ахуйн салбар дээр тухайн тэр өвөлжөө, хаваржааны газар дээр ямар нэг байдлаар давхиулж газар олгох, ямар нэг тусгай зөвшөөрөл олгох, энэ ямар нэг байдлаар энэ үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг болбол бид нар бас тодорхой хамгаалах ёстой, баталгаажуулах ёстой. Тэгэхээр энэ зохицуулалтыг болбол хийж өгсөн.

Эргээд тухайн тэр өвөлжөө, хаваржааны гэрээгээр ашиглуулах энэ газрыг болбол мэдээж ямар журмаар

зохицуулалт хийхийг болбол ЗГ шийднэ, шийдвэрлэнэ, журмыг нь ЗГ гаргана гэдэг зохицуулалтыг хийсэн. Мэдээж энэ болбол орон нутгийн эрх мэдлийн асуудал. ЗГ зохицуулалт журам хийхдээ энэ дээр болбол орон нутгийн эрхийг нь дээдэлсэн, Багийнх нь хурал нь өөрөө онцгой эрхтэй байж, хамтын олонхынхоо шийдвэрээр болбол тухайн өвөлжөө, хаваржааныхаа газар нутгийг хамгаалдаг, чөлөөлдөг, өнжөөдөг, амраадаг л ийм зохицуулалт хийх ёстой л гэсэн байр суурьтай байна.

Ж.Батжаргал: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо хуулийн төсөлтэй, танилцуулгатай холбогдуулж үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Бейсен гишүүнээр тасаллаа. Бейсен гишүүн.

Б.Бейсен: Энэ хуулийн төслийг ерөнхийдөө дэмжиж байгаа. Тэгэхдээ малчдын нийгмийн асуудлыг, нийгмийн баталгааг хангахын тулд ер нь Монгол Улсын хэмжээнд бүх сум, багийн түвшинд сүлжээний асуудлыг шийдэх хэрэгтэй. Тэгэхдээ одоо гишүүд бол энд тэнд тавиулаад байна. Ер нь сүлжээ дунд бүх газар барихаар хэмжээний юмыг ЗГ, ХААЯ-ныхан бас анхаарч байгаад энийг шийдэх шаардлагатай байгаа.

2 дугаарт энэ малчдын нийгмийн баталгаа, энэ өвөлжилтийн байдалтай холбоотой жилийн жилд зуд болж байна, гамшиг болж байна, уул нөмрөгтэй газар яах вэ гайгүй. Тал газар сая Сүхбаатар, Дорнод аймгууд дээр чинь нэлээн хүнд байдалтай боллоо шүү дээ. Тэгэхээр чинь малчдыг орон сууцаар хангах, малын хашааг битүү болгох асуудал дээр нэлээн анхаарахгүй бол 1, 2 хоног шуурлаа гэхэд тэндээ малаа байлгадаг. Тэгээд шуурга бол бараг 7 хоног шуурахгүй шүү дээ. Тэгэхээр чинь энэ асуудал дээр нэлээн анхаараад нэг удаа шийдчихвэл тэгээд л улсын хэмжээнд дараа нь жил болгон шийдэхгүй шүү дээ. Энэ дээр нэг

анхаараад бас хуулийн төсөлдөө тусгаж өгвөл сайн байна.

Ж.Батжаргал: Гишүүд үг хэлж дууслаа. Тэгэхээр энэ Малчны тухай хууль, хамт өргөн мэдүүлсэн хуулиудаар энэ мал аж ахуйн салбарынхаа тогтвортой хөгжлийг хангах хүрээнд малчдынхаа эрх зүйн байдлыг тодорхойлж, тэднийхээ энэ мал маллах арга ажиллагааны чадамжийг нэмэгдүүлэх, бас ерөөсөө энэ мал аж ахуйн салбарыг өөрийг нь энэ бэлчээр нутгаас нь салгаж ойлгох боломжгүй. Тийм учраас энэ бэлчээрийн зохистой ашиглалтын зөв хэлбэрийг тогтоох тухай асуудал нэг.

2 дугаарт байгалийн эрсдэл даах чадамжийг нэмэгдүүлэх тухай асуудал байгаа юм. Гэхдээ энд 2 талтай. Төр мэдээж аюулгүй байдлын юу, аюулгүй нөөцийнхөө бүрдүүлэлтийн асуудлыг шийднэ. Дээр нь малчид маань өөрсдөө эрхэлж байгаа аж ахуйнхаа өвөл, хаврын бэлтгэл ажлыг бүрэн хангах ёстой. Тийм учраас энэ зохистой дадлын асуудлыг энэ хуулийн төсөл рүү их тодорхой оруулж ирсэн. Ер нь бараг үндсэндээ мал аж ахуйн үйлдвэрлэлийн технологи бүр дээр нь энэ зохистой дадлыг нэвтрүүлэх, үүгээрээ дамжуулж малчдынхаа эрх, үүргийг их тодорхой болгосон.

Дээрээс нь үнэхээрийн мал сүрэг үндэсний баялаг, төрийн хамгаалалтад байх ёстой юм бол энэ малчдад, мал аж ахуйн салбарт төрөөс анхаарах асуудалд үзүүлэх дэмжлэгийнх нь асуудлыг энэ хуулиар тодорхой болгосон. Мэдээж хуулийн төслийг хэлэлцэхийг нь дэмжээд, хэлэлцүүлгийн явцад тал бүрээсээ ярилцаж илүү сайжруулж гаргах тухай асуудал байгаа нэг.

2 дугаарт ер нь 2, 3 хуулиудыг дагуулж Газрын тухай хуульд, тэр тусмаа Газрын тухай хуулийн тэр бэлчээрийн газрын зохистой ашиглалтын асуудал дээр нэлээн харилцаануудыг зохицуулахаар тусгасан энэ олон төслүүдийг нэгтгэж, үзэл

баримтлалынх нь хувьд нэг болгох тухай асуудал байгаад байгаа бидэнд бол. Тэгж байж бид нарын шийдэж чадахгүй яваад байгаа асуудлыг энэ цогцоор нь зөв шийдэх асуудал гарна гэж би ингэж л харж байгаа.

Ингээд Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг үзэл баримтлалынх нь хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн одоо саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Хуралдаанд оролцсон гишүүдийн 60 хувийн саналаар хуулийн төслүүдийг хэлэлцэхийг дэмжлээ. Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Наранбаатар гишүүн танилцуулах уу? Наранбаатар гишүүн танилцуулна. Энэ асуудлыг хэлэлцэж дууслаа.

11.09 цаг

Хоёр.Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Дараагийн асуудалдаа орёе. Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн талаарх танилцуулгыг Монгол Улсын ЗГ-ын гишүүн, ХХААХҮ-ийн сайд Болорчулуун танилцуулгыг хийнэ. Болорчулуун сайдын микрофоныг өгье.

Х.Болорчулуун: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Мал, амьтнаас хүнд халдварладаг өвчнийг зооноз гэх бөгөөд дэлхий дээр 1500 орчим хүний халдварт өвчин бүртгэгдсэний 60 хувь нь зооноз өвчин байна. Жил бүр хүний 4-өөс 5 халдварт өвчин шинээр бүртгэж байгаагаас 3-аас 4 нь буюу 75-аас 80 хувь нь амьтнаас хүн халдварлаж, зооноз өвдсөн байгааг судалгаагаар тогтоосон. Нийт зооноз өвчний 60 хувь нь сүүлийн 20 жилд

шинээр бүртгэсэн зооноз өвчний 80 хувь нь вирусээр үүсгэгдсэн байна. Монгол Улсад хүний болон мал, амьтны зориулалттай эм, био бэлдмэл, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн, тэжээлийн нэмэлтийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, хадгалах, худалдах, түгээх, хэрэглэх, хянах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулиар зохицуулж байна.

Эмийн тухай хууль 1998 онд батлагдаж, 2006 онд нэмэлт, өөрчлөлт оруулж, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль болгосон бөгөөд 2010 онд тус хуулийг шинэчлэн найруулснаас хойш нийтдээ 7 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан хэдий ч зарчмын хувьд мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, тэжээлийн нэмэлтийн талаарх зарчмын суурь зохицуулалт, хяналт шалгалтын талаар бүрэн тусгагдаагүй.

Түүнчлэн Монгол Улс 1989 онд Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага, 1997 онд Дэлхийн худалдааны байгууллагын гишүүнээр элссэн бөгөөд гишүүн орны хувьд дээрх байгууллагуудын батлан гаргасан стандарт, удирдамж, заавар, зөвлөмжид нийцүүлэн үндэсний бодлого, хууль тогтоомжийг өөрчилж, шинээр боловсруулах үүрэг хүлээсэн байдаг. Одоо мөрдөж байгаа Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд хүний эмнэлгийн зориулалттай эм, түүний төлөө уламжлалт эм, био бэлдмэл, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, хадгалах, худалдах, түгээх, хэрэглэх, хянах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулалтыг нарийн тусгагдсан бөгөөд мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйжилтийн бэлдмэл, тэжээлийн нэмэгдлийн талаарх зохицуулалтыг бүрэн тусгаагүй байдаг.

Дэлхий дахинд мал, амьтны эмийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл хурдацтай

хөгжиж байгаа нь мал, амьтны өвчний оношилгоо, эмчилгээний шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэх, чанар, аюулгүй байдлыг хангах, эмийн худалдаа, хангамж, эмийн бүртгэл, баталгаажуулалт, эмийн нэгдсэн цахим бүртгэлийг нэвтрүүлэх, эмийн зохистой хэрэглээ, төрөөс баримтлах зарчим, мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгслийн био бэлдмэл, оношлуур, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйжилтийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн зөвшөөрөл олгох, хяналт шалгалт зэрэг хууль, эрх зүйн зохицуулалтыг цогцоор нь тусгах хэрэгцээ, шаардлага бий болоод байна. Иймд дээрх зохицуулалтыг тусган Мал, амьтны эм, тэжээлийн нэмэгдлийн тухай хуулийн төслийг 7 бүлэг, 24 зүйлтэйгээр Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, батлагдсан үзэл баримтлалд нийцүүлэн боловсруулсан болно.

Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөлтэй уялдуулан Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх, Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах, Зар сурталчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулсан.

Хууль батлагдсанаар эмийн чанар, аюулгүй байдал, хангамж сайжирч, хүнсний аюулгүй байдлыг хангахад төр болон хувийн хэвшлийн үүрэг, хариуцлага нэмэгдэнэ. Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага, Дэлхийн худалдааны байгууллага болон бусад олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, мал, амьтны болон нийтийн эрүүл мэндийг хамгаалах

бодлого, чиглэл, стратеги, үйл ажиллагааг тодорхойлсон эрх зүйн орчин бүрдэнэ. Мал, амьтны гоц халдварт, халдваргүй шимэгчлэх өвчнөөс урьдчилан сэргийлэх болон эмчлэх арга хэмжээний үр дүн сайжирч, мал, амьтны өвчний гаралт, тархалт, өвчлөл буурч, хүн ам, мал, амьтны эрүүл мэндэд учруулах эрсдэл буурах юм. Хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж өгнө үү.

Ж.Батжаргал: Болорчулуун сайдад баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хүрэлцэн ирсэн ажлын хэсгийг танилцуулъя. Хаянгаагийн Болорчулуун ХХААХҮ-ийн сайд, Энхбаатарын Цолмонжаргал ХХААХҮЯ-ны Хуулийн хэлтсийн дарга, Хөхөөгийн Алтангэрэл ХХААХҮЯ-ны Мал эмнэлгийн бодлогын асуудал эрхэлсэн ахлах шинжээч, Бямбын Болдбаатар Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийн газрын дарга, Сандагийн Батхуяг Мал эмнэлгийн ерөнхий газрын Статистик, дүн шинжилгээ хариуцсан ахлах мэргэжилтэн. Хуулийн төслийн танилцуулгатай холбогдуулж асуух асуулттай гишүүд нэрсээ өгье. Наранбаатар гишүүнээр тасаллаа. Наранбаатар гишүүн асуултаа асууя.

Н.Наранбаатар: Хуулийн төслийг бол ер нь дэмжиж байгаа юм. Тэгээд 1 товчхон асуулт байна. Энэ одоо бид хүнсний аюулгүй байдал гэдэг болбол хамгийн чухал. Тэр дотроо ямар мах өнөөдөр бид идэж байгаагаа бол мэдэхгүй байна шүү дээ. Ялангуяа энэ төв сууриныхан бол. Тэр малчин малдаа ямар тэжээл, ямар эм тариа өгснийг мэдэх арга алга байна шүү дээ. Зах дээр очоод л бид мах худалдаж аваад л ингээд л идэж байгаа юм.

Тэгээд өнөөгийн нөхцөлд энэ малчдын хэрэглэж байгаа тэр эм, тариаг ямар байдлаар хяналт тавиад байгаа юм бэ? Энэ хууль батлагдсанаараа ямар зохицуулалтууд хийж өгсөн юм бэ? Цаашидаа ямар баталгаа байгаа юм бэ? Эрүүл мах идэх,

эрүүл хүнс хэрэглэх ямар баталгааг энэ хууль батлагдаж гарснаараа хангах юм бэ гэдэг дээр тодруулга өгөөч.

Ж.Батжаргал: Хариулъя. Болорчулуун сайд уу? Хэн бэ? Ажлын хэсгийн 2 дугаар микрофон.

Х.Алтангэрэл: Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Ер нь малын эмийн хяналт бол өмнө нь бол мэргэжлийн хяналтын байгууллага хариуцаж хийж байсан. Өнгөрсөн оноос салбарын, Хүнс, хөдөө аж ахуйн яамныхаа харьяанд ингээд салбарын чиг үүрэг бол бүтнээрээ орж ирсэн байгаа. Энэ хуулийн төсөл дээр бол ерөнхийдөө эмийн хяналтыг бол хянах байцаагчдын эрх, үүргийг бол оруулж өгсөн байгаа 1 дүгээрт.

2 дугаарт хуулийн төслийн 4 дүгээр бүлэг бол энэ тухайн эмийг хэрэглэх, тэрийг илрүүлэх, эмийн үлдэгдлийг илрүүлэх энэ тандалт төлөвлөгөө, мэргэжлийн байгууллагуудын чиг үүргийг бол энэ 4 дүгээр бүлэг дээр бол нарийвчлаад тусгаад өгчихсөн байгаа.

Ж.Батжаргал: Тэмүүлэн гишүүнийг асуулт асуух гишүүдийн нэрсэнд нэмээд, Тэмүүлэн гишүүн асуултаа асууя.

Г.Тэмүүлэн: Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл ЗГ-аас өргөн баригдсан. Энэ дээр бид бүхний хувьд нэг зүйлийг л нэг би анхаармаар л байна уу гэж бодоод байгаа. Тэгээд манай яамны мэргэжлийн хүмүүс маань бас байна. Мал, амьтны эрүүл мэндтэй холбоотой гол үйл ажиллагааг явуулж байгаа өнөөдөр үндсэндээ анхан шатан дээр сум дээр, баг дээр мал, амьтны эрүүл мэндийн үйлчилгээг хийж байгаа, гүйцэтгэж байгаа байгууллага болбол энэ мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд байгаа. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд. Тэгээд өнөөдөр бид бүхэн ер нь энэ мал эмнэлгийнхээ үйлчилгээний нэгжүүдийг,

малын үржил технологийнхоо нэгжүүдийг дандаа хувийн хэвшилээр хийлгэж байгаа. Хувийн хэвшилээр хийлгэж байгаа. Сум болгон дээр очихоор яг хангалттай хүрэлцээтэй энэ үйлчилгээний нэгжүүд болбол бас байхгүй байна. Үржлийнх бол үндсэндээ байхгүй байна. Мал эмнэлгийн одоо мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд болбол харьцангуй арай сум болгонд бол байна. Гэхдээ ачаалал нь шал өөр өөр, харьцангуй өөр өөр байгаад байгаа юм. Зарим багтаа хүрч очиж чаддаггүй, хүн хүч нь хүрдэггүй, техник технологи нь бас байдаггүй, дэд бүтэц нь байдаггүй, эмийнхээ хангамж хүрэлцээгээ бас бий болгож чаддаггүй.

Тэгэхээр бид нар Монголын төр одоо юу гэдэг юм хамгийн чухал хүнсний аюулгүй байдалтай холбоотой асуудлаа хувийнхнаараа гүйцэтгүүлж байгаа мөртөө нөгөө талдаа одоо юу гэдэг юм бид нар энэ технологийнх нь цаг хугацаанд чанартай энэ мал эмнэлгийн үйлчилгээг гүйцэтгэхэд чадавхыг бий болгоход болбол анхаарах зайлшгүй шаардлагатай болчихоод байгаа юм. Тэгэхээр хувийнхаа мал эмнэлгийн нэгжүүдийг бид нар хэрхэн чадавхтай болгох юм бэ, хэрхэн дэмжих юм бэ, хэрхэн одоо юу гэдэг юм энэ үйл ажиллагааг нь сайжруулах юм бэ гэдэг асуудал дээр одоо ер нь ямар зохицуулалтууд хийж байгаа юм бол? Гол анхаарах асуудал бол энэ байгаад байна.

Гэтэл манай одоо юу гэдэг юм сум болгонд манай мал эмнэлгийн нэгжүүд байгаа төрийн, төрийнхөн. Төрийнхөн бол зөвхөн зүгээр л гүйцэтгэл, үр дүнд нь хяналт тавьж байгаа байхгүй юу тэнд. Тэднээс тэд нар одоо юу гэдэг юм яг гар биечилж ороод, суман дээр, баг дээр үйл ажиллагаа эрхэлдэггүй, ямар нэг эм тариа хийдэггүй, ямар нэг мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлдэггүй, ямар нэг мал үржлийн технологийн ажлуудыг хийдэггүй. Тэгэхээр энийг ер нь яаж өөрчлөх юм бэ? Тэгэхгүй болбол анхан шатан дээр бид нар хувийн хэвшилдээ

даатгаад орхидог. Өнөөдөр энэ яг технологийн ажлуудын үйлчилгээний хөлснүүд чинь өөрөө бас төрөөс санхүүжүүлж байгаа боловч хангалттай тухайн тэр байгууллагууд өөрөө өөрсдийнхөө бие даасан байдлаар авч явах, санхүүгийн хувьд бие даагаад босоод ирэх, цаашидаа хөгжсөөд дэвжээд явах хөлс хураамж болбол бас байхгүй байна. Бог дээр 250 байгаа байх, бод дээр 500 байгаа байх. Энэ болбол өөрчлөгдөх ёстой.

Бид нар энэ өөрчлөх шийдвэрийг уг нь ЗГ-т олгосон. Одоогийн байдлаар болбол үйлчилгээний хөлс хураамжууд нэмэгдсэн зүйл байхгүй байгаад байна. Зах зээлийнх нь зарчмаар уг нь явуулдаг байх ёстой байх. Мэдээж тэгэхдээ зах зээлийн зарчмаар явлаа гээд өнөөгийн энэ хүнд цагт болбол малчин хүн үйлчилгээний хөлсийг төлж дийлэхгүй байх л даа. Тэгэхдээ тодорхой хугацаанд Монголын төр үйлчилгээнийх нь хөлс дээр татаас, урамшууллуудыг өгөөд, тухайн тэр байгууллагууд санхүүгийн хувьд бие даагаад босоод ирэх боломжийг бүрдүүлмээр байна.

Хэрэв ингэхгүй болбол үндсэндээ энэ малын эрүүл мэнд болоод технологийнхоо ажил дээр бид нар бүүр том суурь реформ өөрчлөлтийг хийвэл яасан юм бэ? Суурь том реформ өөрчлөлтийг хийвэл яасан юм бэ? Яг одоогийнхоо яг энэ байдлаар болбол чанартай ажил, үйлчилгээг гүйцэтгэх нь, хүртээмжтэй байлгана гэхэд болбол боломж бололцоо байхгүй байгаад байна. Та хэд маань бас яг энэ дээр ямар бодлогын ер нь байр суурьтай байгаа юм бэ? Ямар зохицуулалтууд байгаа юм бол?

Ж.Батжаргал: Хариулъя.
Болорчулуун сайд.

Х.Болорчулуун: Яг амьдрал дээр бол мал эмнэлгийн үйлчилгээ орон нутагт суларсан, суларч ажиллаж ирсэн нь болбол хэн бүхэн мэдэж байгаа. Энэ болбол малын эмч нараас болоогүй. Энэ бол төрөөс болсон асуудал гэж хэлэх

байна. Яагаад гэвэл малын мал эмнэлэг хувьчлагдсан улсынх байж байгаад. Тэгтэл төрийн өмнөөс тэр мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх хангалттай хөлсийг нь олгож өгөхгүй, төсөв дээрээ тавихгүй энэ байдалтай холбоотой мал эмнэлгийн үйлчилгээ суларсан гэж хэлж болно. Ялангуяа гоц халдварт өвчин, тарилга туулгын нэг малд хэрэглэх ашиглах үйлчилгээний хөлс хэт бага байлаа шүү дээ. Бог мал 250 байсан, бод мал 450 байлаа. Харин бид нар болбол өнгөрсөн жилээс бас хөөцөлдөж байж нэг бодыг одоо үхэр, тэмээ, адууг болбол мянган төгрөг болгосон. Богийг 450, 350 төгрөг болгосон. Өөр ч энэ бага.

Ингээж бас үйлчилгээнийх нь хөлсийг нэмж байж, төсөв дээр суулгаж байж, мөн бусад өвчин тарилгын үйлчилгээний хөлсийг орон нутгийн төсөв дээр суулгаж байж энэ мал эмнэлгийн үйлчилгээ болбол малчны хотондоо, мал бүрдээ болбол чанартай очих нөхцөл бүрдэх юм гэдгийг бас хэлэх байна.

2 дугаарт харамч хүн 2 төлнө гэгчээр вакцин, тарилгын санхүүжилтийг улсын төсөв дээр маш их татганаж, тавих нь их багассан байсан. Үндсэндээ зөнд нь орхисон. Харин хүнсний хангамж, аюулгүй байдлын 33 дугаар тогтоолын хүрээнд энэ 4,5, 5 жилд 144 тэрбум төгрөгийг зөвхөн мал, малын вакцин, тарилга, туулга, эмийн үйлчилгээнд одоо хэрэглэхээр тавьсан нь болбол одоо энэ вакцин, эм, тарилгын хүртээмжийг болбол нэмэгдүүлсэн гэж хэлж болно. Вакцин тарилгын хувьд бол төсөв дээр бол хангалттай тавиад эхэлсэн өнгөрсөн жилээс авхуулаад.

Тийм ч учраас малын өвчин бас буурах хандлага бий болсон гэдгийг хэлэх байна. Тэрнээс биш одоо нэг хэсэг та бүхэн мэдэж байгаа 21 аймагт шүлхий гарлаа шүү 3 жилийн өмнө. Үхрийн товруутах өвчин гэж шинээр урьд өмнө бүртгэгдэж байгаа өвчин Монголд гарлаа. 16 оноос мялзан өвчин гэж 16 оноос өмнө байгаагүй гарлаа. Ийм, ийм

шинэ, шинэ өвчнүүд бас ингээд малын эмч гэхээсээ илүү энэ төрийн санхүүжилт дээр энэ мал, амьтныг эмчлэх.../минут дуусав/

Ж.Батжаргал: Болорчулуун сайдын микрофоныг өгчихье, гүйцээгээд хариулчих.

Х.Болорчулуун: Мал, амьтныг эмчлэх, эрүүлжүүлэх энэ вакцин, тарилга санхүүжилтдээ үйлчилгээний хөлсийг бага өгч байсан, мөн тарилга вакцины үнийг бага төсөв дээр тавьж байсантай холбоотой малын өвчин их гарч байсан. Энэ байдал бол цаашидаа болбол буурна гэдэгт итгэлтэй байна. Учир нь бол вакцин, тарилгын санхүүжилтийг бол хангалттай жил жилдээ тавиад өгч байгаа. Мөн үйлчилгээний хөлс нэмэгдэж байгаа. Үйлчилгээний хөлс дахиад ч гэсэн мөнгөний ханшны инфляцтай уялдуулж нэмэгдүүлэхгүй болбол одоо малын эмч нар чинь хөдөө нэг дор сумын төв дээр үйлчилгээ явуулчихгүй шүү дээ багуудаар явна. Маш их бензин тосны зардал их гардаг, янз бүрийн мал баригчаас авхуулаад. Тэгэхээр энийг болбол бас инфляцтай уялдуулж үргэлж нэмж байх шаардлага бас зүй ёсоор бас тавигдаж байгаа юм. Энэ л одоо сайн байж мал өвчингүй эрүүл байх үндэс нэмэгдэнэ гэдгийг бас хэлэх байна.

Ж.Батжаргал: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо хуулийн төсөлтэй холбогдуулж санал хэлэх гишүүд байна уу? Нэрсээ өгөөрэй. Алга байна.

Тэгэхээр энэ Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хууль дээр бид 2 зүйлийг хэлэлцүүлгийн түвшинд анхаарах ёстой болов уу гэж бодоод байгаа юм би бол. Энэ мал аж ахуйн салбарын ер нь тогтвортой хөгжлийг хангая, бүтээгдэхүүний борлуулалтыг өөрийг нь нэмэгдүүлье гэвэл бидэнд хийх ажлууд их байгаа. Энэ дагуу бид нар холбогдох арга хэмжээнүүдээ аваад яваад байгаа. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульдаа нэлээн

томоохон өөрчлөлт оруулаад эрүүл бүс нутгийн тухай, хамгаалагдсан аж ахуйн тухай, мөшигөлтийн системийнхээ тухай ер нь нэлээн тодорхой зүйлүүд оруулчихсан. Одоо энэ Хүний эм, эмнэлгийн хэрэгслийн сонсголтой холбогдуулаад эргээд харахаар зэрэг наад эм, тарианууд чинь өөрөө чанар нь ямар вэ гэдэг асуудал байгаад байгаа юм. Тэгэхээр үүнийг бид их бодмоор байна 1.

2 дугаарт ер нь мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортынхоо чиг баримжааг харгалзаж, тухайн импортлогч орны хүлээн зөвшөөрөгдсөн тэр эм, био бэлдмэлүүдээр малаа эрүүлжүүлэх ажлыг хийж байж сая бид тэр зорилтот зах зээлд өөрөө эргэлзээгүй байх асуудал яригдах юм биш биз гэдэг юм байгаад байгаа юм. Үүнийг ер нь ямархуу түвшинд хэдүүлээ анхаарах ёстой вэ гэж нэг.

2 дахь зүйл тэжээлийн нэмэлт дээр бид онцгой анхаарах ёстой. Одоо энэ олон судлаачид, энэ Малчин өрхийн холбооны ч, малчны ч, сая Уламжлалт мал аж ахуйд тэр уур амьсгалын өөрчлөлтөөс үзүүлээд байгаа сөрөг нөлөөллийг бууруулах хуулийн төслүүдийг ярихад Монгол мал ер нь эрдэс, амин дэм, уургийн дутагдалд ороод, нэлээн давжаарч байгаа тухай яриад байгаа юм. Үүнийгээ бэлчээрээсээ бүрэн нөхөж чадахгүй байна гэдэг юм яриад байгаа. Тэгвэл тэжээлийн нэмэлт дээр бид онцгой анхаарах ёстой. Яаж

тэр мал сүргээ энэ дутагдлаас нь гаргах арга хэмжээг ер нь авах ёстой юм бэ гэдэг асуудал байх нь. Тэгэхээр үүнийг хэлэлцүүлгийн явцад бид нэлээн анхаарч, энэ хуулийн төслийг илүү сайжруулж гаргах ёстой болов уу гэсэн би бол ийм бодолтой байгаад байгаа шүү.

Ингээд Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Хуралдаанд оролцсон гишүүдийн 60 хувь дэмжлээ. Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Дамдинням гишүүн танилцуулах уу? Чуулганы нэгдсэн хуралдаанд 4 дэх өдөр. Дамдинням гишүүн танилцуулна.

11.28 цаг

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдаан өндөрлөж байна. Хуралдаанд ирж оролцсон Байнгын хорооны гишүүд, ажлын хэсгийнхэндээ баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА

